

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 оны 07 дугаар сарын мэдээлэл

2023.07.24.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 12 дугаар хуралдаан 2023.06.29 ний өдөр хуралдаж 5 асуудлыг хэлэлцэв. Уг хуралдаанаар Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай тогтоол батлав.

-Алтан овооны 110 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг суманд ирж ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсэг 2023.07.19 нд сумын ИТх-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдыг оролцуулан хуралдаж, үүрэг даалгавар өгсөн.

Энэ хүрээнд сумын төрийн байгууллагуудын ээлжийн амралт эдэлж буй албан хаагчдыг 2023.07.24 ний өдрөөс эхлэн 5 хоног ажилд нь оруулахаар шийдвэрлэж, төрийн албан хаагчдыг Алтан овооны тахилгын бэлтгэл ажилд дайчлан ажиллаж байна.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

“Ажил олгогч, бизнес эрхлэгчдийн бүсийн зөвлөгөөн”- 2023.07.20 ны өдөр тус суманд зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнөөр:

а.Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн систем EJOB платформын танилцуулга,

б. Орон нутагт бизнес эрхлэх боломж хэлэлцүүлэг

в. Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримталж буй бодлого

г. Хоршоо хөгжүүлэх сангийн талаар зэрэг асуудлыг хэлэлцэж, сургалт зохион байгууллаа.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР